

Шашны байгууллагын тухай Монгол улс ба БНХАУ-ын хууль тогтоомжийг харьцуулан авч үзсэн нь

М.Отгонбаяр, доктор (PhD) профессор
МУИС, Философи, шашин судлалын тэнхим
Сэргэлэн (Siriguleng), докторант

Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухааны Академийн Философи,
Шашин судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

***Хураангуй:** Бид энэ өгүүлэлдээ Монгол улс ба БНХАУ дахь төр, сүм хийдийн харилцааны эрх зүйн зохицуулалт, хоёр улсын шашны талаар явуулж буй бодлогын хүрээнд шашны байгууллага байгуулах, зөвшөөрөл олгох, бүртгүүлэх, үйл ажиллагаа явуулах асуудлаарх хууль тогтоомжийг харьцуулан судалж, адил болон ялгаатай талыг илрүүлэх, сайн болон сургамжит туршлагыг ойлгон тайлбарлах оролдлого хийлээ. Үүний тулд Төр, сүм хийдийн харилцааны тухай Монгол Улсын хууль, Нийслэл болон аймгуудын нутаг дэвсгэрт шинээр сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журмууд, мөн Хятадын “Шашны Үйл Ажиллагаа Явуулах Газрын (Шашны Байгууллага, Сүм Хийд) менежментийн арга” (宗教活动场所管理办法) -ыг үндсэн эх сурвалж болгон ашиглав.*

Түлхүүр үг: Төр, сүм хийдийн харилцаа, сүм хийд байгуулах, шашны байгууллага

Улс орнууд дахь нийгмийн тодорхой асуудлыг зохицуулах хууль тогтоомжийг харьцуулан авч үзэж, тэдгээрийн нийтлэг болон ялгаатай байдал, шинэчлэлийн хандлагад дүн шинжилгээ хийснээр “... тодорхой хууль эрх зүйн асуудал бусад улсын харьяалалд хэрхэн шийдэгдэх...”¹²⁷-ийг ойлгох, улмаар сайн туршлагыг нэвтрүүлэх, сургамж авах зэрэг ач холбогдолтой юм. Бид энэ өгүүлэлдээ шашны байгууллага байгуулах, зөвшөөрөл олгох асуудлаарх Монгол Улс ба БНХАУ-ын хууль тогтоомжийн зохицуулалтыг харьцуулан авч үзэх, нийгмийн тодорхой үзэгдэл, түүнд хамаатай төрийн бодлого, соёл болон бусад хүчин зүйлсийн хоорондын харилцан холбоо болон ялгааг тодруулах зорилго тавьсан болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Есдүгээр зүйлд “1. Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ. 2.Төрийн байгууллага шашны, сүм хийд улс төрийн үйл ажиллагаа эрхлэн явуулж болохгүй. 3.Төр, сүм хийдийн хоорондын харилцааг хуулиар зохицуулна.” хэмээн заасан.

БНХАУ-ын Үндсэн хуулийн 36 дугаар зүйлд “Төр шашны хэвийн үйл ажиллагааг хамгаална. Хэн ч шашин шүтлэгийг ашиглан нийгмийн хэв журмыг алдагдуулах, иргэдийн эрүүл мэндийг хохироох, үндэсний боловсролын тогтолцоонд саад учруулах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”; “Шашны бүлгүүд болон шашны үйл ажиллагаа нь гадаадын хяналтад байхгүй” хэмээн заажээ.

БНХАУ-д төр нь шашны хэвийн үйл ажиллагааг хамгаалах үүрэг хүлээсэн ба нийгмийн хэв журам, үндэсний боловсролын тогтолцоонд саад учруулах үйл ажиллагаа явуулах, мөн гадаадын хяналтыг хориглосон байна. Харин Монгол улсад төр шашин хоёр харилцан хүндэтгэх бөгөөд тэдгээрийн үйл ажиллагааг заагласан байна.

Шашны байгууллага болон шашны хэргийн асуудлаар Монгол улсад Төр сүм хийдийн харилцааны тухай хууль 1993 онд батлагдсан бол БНХАУ-ын "Шашны хэргийг зохицуулах хууль" 2004 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 426 тоот тушаалаар баталж, 2005 оноос хэрэгжүүлсэн байна. БНХАУ-д 2004 оныг хүртэл шашны хэргийн талаар тусгай хууль

¹²⁷ 美国, 詹姆斯·戈德雷·阿瑟·泰勒·冯·梅伦, 私法比较研究导论: 阅读、案例、材料, 张淞纶译, 中国法制出版社, 2021年, 第一版序言.

байсангүй. 2017 онд тус хуулийг шинэчлэн баталж, 2018 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэлжээ.

Монгол Улсын Төр сүм хийдийн харилцааны тухай хууль нь нийтлэг үндэслэл, төр, сүм хийдийн харилцаа, шашны байгууллагын тухай, бусад зүйл гэсэн дөрвөн бүлэг, 47 заалттай. Энэ хуулийн Шашны байгууллагын тухай бүлэг нь шашны байгууллага, сүм хийд, лам санваартны үйл ажиллагааны эрх зүйн үндэс, шашны сургалт, сүм хийд байгуулах, сүм хийдийн үйл ажиллагааг зогсоох, сүм хийдийн аж ахуйн харилцааг зохицуулах гэсэн 6 зүйл, 27 заалт бүхий байна.

БНХАУ-ын "Шашны хэргийг зохицуулах хууль" (宗教事务条例) нь нийтлэг үндэслэл, зөвшөөрөл олгох ба бүртгэх, шашны байгууллага, шашны үйл ажиллагаа явуулах газар, шашны ажилтан, өмч, барилга байгууламж, аюулгүй байдал, удирдлага, хуулийн хариуцлага, бусад гэсэн 9 бүлэг 76 заалт бүхий байна.

Монгол улс ба БНХАУ-ын төр, сүм хийдийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийг дараах үзүүлэлтээр харьцуулан авч үзье.

Шашны байгууллага

БНХАУ-ын "Шашны хэргийг зохицуулах хууль"-ийн 19 дүгээр зүйлд зааснаар шашны үйл ажиллагаа явуулах байгууллагад Буддын, Христийн, Исламын сүм болон шашны үйл ажиллагаа явуулдаг бусад суурин газрууд орно, сүм болон шашны үйл ажиллагаа явуулах бусад суурин газрыг ялгах стандартыг муж, өөртөө засах орон, хотын ардын засгийн газар тогтоож, шашны хэрэг эрхлэх хэлтсээс боловсруулж, Шашны хэрэг эрхлэх төрийн зөвлөлд мэдээлэх ёстой ажээ.

Харин Монгол улсын Төр сүм хийдийн харилцааны тухай хууль болон журмуудад шашны байгууллага гэдгийн дор шашны тодорхой чиглэлийг зааж өгөөгүй байна.

БНХАУ-ын "Шашны хэргийг зохицуулах хууль"-ийн 20 дугаар зүйлийн 20.4.5 “шашны байгууллага бүртгүүлэхийн тулд шаардлагатай хөрөнгөтэй байх, хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны байх”; “зохион байгуулалт нь боломжийн, хот, хөдөөгийн төлөвлөлтийн шаардлагад нийцсэн, ойр орчмын нэгж, оршин суугчдын хэвийн үйлдвэрлэл, амьдралд саад учруулахгүй байх”; 21дүгээр зүйл “Шашны үйл ажиллагаа явуулах байгууллага байгуулах шашны бүлэг нь оршин суугаа Шиан, хошууны (县) ардын засгийн газрын шашны хэрэг эрхлэх хэлтэст хүсэлт гаргана” зэрэг тодорхой зохицуулалтууд оржээ.

Монгол улсын “Төр сүм хийдийн харилцааны тухай хууль”-ийн гуравдугаар бүлгийн 9 дүгээр зүйлийн 9.1-д зааснаар сүм хийд байгуулах тухай иргэдээс гаргасан өргөдөл, дүрмийг аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал хянан үзэж, зөвшөөрөл олгох эсэх асуудлыг шийдвэрлэх ба зөвшөөрлийг үндэслэн улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сүм хийдийг бүртгэхээр зохицуулсан байна.

БНХАУ-ын Төрийн шашны хэрэг эрхлэх газраас 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдөр баталсан “Шашны Үйл Ажиллагаа Явуулах Газрын (Шашны Байгууллага, Сүм Хийд) менежментийн арга” 《宗教活动场所管理办法》 гэсэн нэг журмаар сүм хийдийн үйл ажиллагааг зохицуулж байна.

Монгол улсын Үндсэн хууль (1992 он), Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль (1993) онд батлагдсанаас хойш 12 жилийн хугацаанд шашны байгууллагаа байгуулах, бүртгүүлэх үйл ажиллагааг зохицуулсан тодорхой журамгүй явж иржээ. Хуульд зааснаар аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан анхны журам (Нийслэл, Хэнтий аймаг) 2005 онд гарсан бол сүүлчийнх нь 2019 (Өвөрхангай, Төв, Ховд), 2021 (Говь-Алтай) онд батлагдсан ба Архангай, Дорнод, Сүхбаатар аймгууд холбогдох журамгүй байна.

Монгол улсад шашны байгууллага байгуулах, зөвшөөрөл олгох, бүртгэх, зөвшөөрлийг цуцлах талаар гаргасан аймаг, нийслэлийн нийт 19 журам нэр, бүтэц ялгаатай /3-7 бүлэг/, зөвшөөрөл олгох үйл ажиллагааны дэс дараалал, бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт, зөвшөөрлийн хугацаа, зөвшөөрлийг сунгах хугацаа, тэр ч байтугай журмыг баталсан субъект ялгаатай байна.

Төр, сүм хийдийн харилцааны хуульд нийцүүлэн аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаас баталсан шашны байгууллагыг бүртгэх, зөвшөөрөл олгох, үйл ажиллагааг зогсоох үйл ажиллагааг зохицуулсан журмуудын нэрийг харьцуулан авч үзье.

Хүснэгт №1

№	Журмын нэр	Аймаг	баталсан огноо
1	Иргэд сүм хийд байгуулах, сүм хийдийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавих журам	Баян-Өлгий	2017
2	Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт шашны байгууллага байгуулах, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох журам	Баянхонгор	2017
3	Булган аймгийн нутаг дэвсгэрт сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам	Булган	2015
4	Аймгийн нутаг дэвсгэрт шашны байгууллага байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох, хяналт тавих журам	Говь-Алтай	2021
5	Аймгийн нутаг дэвсгэрт сүм хийдийн зөвшөөрөл олгох, үйл ажиллагаа явуулах , зөвшөөрлийг цуцлахад баримтлах журам	Говьсүмбэр	2015
6	Дархан-уул аймгийн нутаг дэвсгэрт сүм хийд байгуулах, зөвшөөрөл олгох, хяналт тавих, сунгах, цуцлах журам	Дархан-Уул	2018
7	Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт сүм хийд байгуулах, зөвшөөрөл олгох, цуцлах, хяналт тавихад баримтлах журам	Дорноговь	2017
8	Дундговь аймгийн нутаг дэвсгэрт шашны байгууллага байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох, хугацааг сунгах журам	Дундговь	2015
9	Завхан аймгийн нутаг дэвсгэрт сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулах, зөвшөөрөл олгох, цуцлах журам	Завхан	2018
10	Аймгийн нутаг дэвсгэрт сүм хийд, шашны байгууллага байгуулж, үйл ажиллагаа явуулах журам	Орхон	2009
11	Өвөрхангай аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах, шашны байгууллагад зөвшөөрөл олгох, хяналт тавих журам	Өвөрхангай	2019
12	Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт шинээр шашны байгууллага байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам	Өмнөговь	2017
13	Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт сүм хийд байгуулж, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам	Сэлэнгэ	2009

14	Төв аймгийн нутаг дэвсгэрт шашны байгууллага байгуулах зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагаанд хяналт тавих журам	Төв	2019
15	Увс аймгийн нутаг дэвсгэрт сүм, хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам	Увс	2009
16	Ховд аймгийн нутаг дэвсгэрт шашны байгууллага, сүм хийд байгуулах, зөвшөөрлийн хугацаа сунгах, үйл ажиллагаанд хяналт тавих журам	Ховд	2019
17	Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт төр, сүм хийдийн харилцааг зохицуулах журам	Хөвсгөл	2016
18	Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт сүм хийд байгуулах, шашны үйл ажиллагаа явуулах, зөвшөөрөл олгоход баримтлах журам	Хэнтий	2005
19	Нийслэлийн нутаг дэвсгэрт шинээр сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам	Улаанбаатар	2005

Эндээс үзэхэд журмуудын нэр утгын хувьд ялгаатай, тухайлбал, сүм хийд үү, шашны байгууллага уу, сүм хийд болон шашны байгууллага хамт уу гэдэг асуудлыг нэр томъёоны хувьд ялгаж салган тодорхойлох, сүм хийд байгуулахад зөвшөөрөл олгох юм уу, эсвэл үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох журам уу зэргийг оновчтой тогтоох, нэр томъёоны тодорхойлолтыг дахин боловсруулах, тэдгээрийг нэг утгаар ойлгох, хэрэглэж хэвших шаардлагатай байна.

Шашны байгууллага байгуулах хүсэлт гаргах ба түүнийг хүлээн авах субъект

Монгол улсын Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2005 оны 74 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт шинээр сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам” (цаашид журам гэх) ба Хятадын “Шашны үйл ажиллагаа явуулах газрын (Шашны Байгууллага, Сүм Хийд) менежментийн (管理) арга” (цаашид арга гэх)-д заасан байдлыг авч үзвэл шашны байгууллага байгуулах, үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох явц дахь шашны байгууллага байгуулахыг санаачлагч ба санаачлагыг хүлээн зөвшөөрөгч хоёр ялгаатай байна.

Монгол улсын аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт шашны байгууллага байгуулах субъект нь Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д зааснаар иргэд байна. Хуулийн дагуу аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт шашны байгууллага байгуулах журмуудад (19) сүм хийд, шашны байгууллага байгуулах хүсэлтийг иргэн(иргэд) гаргахаар зохицуулсан байна.

БНХАУ-ын аргын 9 дүгээр зүйлийн тогтоолд зааснаар шашны байгууллага байгуулах хүсэлтийг гаргах субъект нь шашны бүлгэм (гишүүд нь лам санваартан, сүсэгтний төлөөлөгч) байна. Хятадын журмын “Орон нутгийн шашин шүтлэгтэй иргэд ихэвчлэн хамтын шашны үйл ажиллагааг явуулах шаардлагатай байх”; “шашны үйл ажиллагаа явуулах санваартан болон энэ хуулийн заалтыг дагаж мөрддөг хүмүүс байх” гэсэн заалт монголын хууль, журмуудад заасан иргэн, иргэдээс ялгаатай байна.

Монгол улсад шашны байгууллага байгуулах хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх субъект нь Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д зааснаар “аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хянан үзэж, зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.” БНХАУ-ын “Арга”-ын 10.11.12 дугаар зүйлийг үндэслэвэл, Муж(Өртөө Засах Орон)-ын шашны хэрэг эрхлэх хэлтэс хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх эрх, үүргийг хэрэгжүүлдэг байна.

Монгол улсын хууль, журамд шашны байгууллага байгуулах тухай хүсэлт, өргөдөлийг хүлээн авч, хариу өгөх хугацааг тодорхой тогтоож өгөөгүй байна. Харин БНХАУ-ын аргад

“ажлын 90 өдрөөс хэтэрч болохгүй” хэмээн хугацааг тогтоожээ. Тухайлбал, Шиан, хошууны (县) ардын засгийн газрын шашны хэрэг эрхлэх хэлтэс өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хянан дүгнэлтээ гаргаж, оршин суугаа хот, суурин газры (тойрог 区或市) ардын засгийн газрын шашны хэрэг эрхлэх хэлтэсд мэдүүлнэ”; тойрог (区) -ийн шашны хэрэг эрхлэх хэлтэс нь шияан (зээл, хороо)-ын шашны хэрэг эрхлэх хэлтэсийн мэдүүлгийг хүлээн авсан өдрөөс эхлэн ажлын 30 өдрийн дотор, шашны байгууллага байгуулах хүсэлтийг зөвшөөрсөн буюу эс зөвшөөрсөн тогтоолыг муж(өөртөө засах орон)-ын шашны хэрэг эрхлэх хэлтэст мэдүүлж, данслуулах ёстой. Муж (өөртөө засах орон)-ын шашны хэрэг эрхлэх хэлтэс нь тойрог(区)-ын шашны хэрэг эрхлэх хэлтэсийн мэдүүлгийг хүлээн авсан өдрөөс эхлэн ажлын 30 өдрийн дотор зөвшөөрөх юмуу эс зөвшөөрөх тогтоол гаргах хэрэгтэй” гэжээ. Энэ мэт бүртгэлийн цаг хугацааг журамлан зохицуулсан нь шашны байгууллага байгуулах санаачлагчдад цаашдын үйл ажиллагаагаа төлөвлөхөд дөхөм үзүүлдэг байна.

Шашны байгууллага байгуулахын тулд бүрдүүлэх бичиг баримт

“Нийслэлийн нутаг дэвсгэрт шинээр сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам”-д зааснаар: шашны байгууллага байгуулах шаардлага; үйл ажиллагааны онцлогийг тусгасан өргөдөл; сүм хийдийн дүрэм; шашны байгууллага байгуулахаар санал нэгдсэн хүмүүсийн хурлын шийдвэр; дэлгэрэнгүй тэмдэглэл; анх санаачлагчдын товч бүртгэл; удирдах байгууллагын гишүүд; үйл ажиллагаа явуулах байршил, газрын зөвшөөрөл олгосон гэрчилгээ; үйл ажиллагаа явуулахад шаардагдах байр танхим барих, худалдан авах, түрээсээр ашиглах үеийн нөхцөл болон холбогдох бусад газраас авсан зөвшөөрөл, гэрээ; шашны зан үйл явуулахад шаардагдах ном, судар, бусад хэрэгслийн жагсаалт, хөрөнгө, санхүүгийн хэмжээ; шашны байгууллагын зорилго, шүтэж итгэдэг номлолын үндсэн үзэл санаа, үйл ажиллагааны зарчим, гадаад харилцааг тайлбарласан танилцуулга; шашны байгууллагаас шүтэн бишрэгчид, итгэгчдийн дунд зохиох ажлын гол агуулга, чиглэл; номлол сургаал айлдагч гадаадын зөвлөх багшийн дэлгэрэнгүй бүртгэл, фото зураг; Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны болон ажиллаж буй газрын зөвшөөрөл, тодорхойлолт; тухайн дүүрэг, хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллагын байршил, лам санваартан нарын үнэмлэхүй тоог харгалзан дүүргийн ИТХ-ын тэргүүлэгчид, хорооны засаг даргын өгсөн санал; улсын бүртгэлийн газраас нэр давхацсан эсэхийг тодруулсан лавлагаа гэсэн 13 зүйл, 18 төрөл бичиг баримт бүрдүүлэх шаардлагатай байна.

БНХАУ-ын аргад тавьсан шаардлага дагуу шашны байгууллага байгуулах хүсэлт гаргахдаа өргөдлийн маягт бөглөх ёстой. Ингэхдээ дараах бичиг баримтыг бүрдүүлэх ёстой байна. Үүнд: 1) сүсэгтнүүд хамтран шашны үйл ажиллагааг тогтмол явуулдаг тухай тодорхойлолт, 2) хуулийн төлөөлөгчийн нэр, 3) шашны үйл ажиллагааг удирдах санваартан эсвэл үндэсний шашны бүлгийн шаардлагад нийцсэн хүний иргэний болон өрхийн бүртгэлийн үндсэн мэдээлэл (овог нэр, хүйс, боловсрол, мэргэжил, эрхэлж бий ажил, гэрийн хаяг, утас мэдээлэл), багийн гишүүдийн иргэний үндсэн мэдээлэл, 4) шашны байгууллага байгуулахаар санаачлагчдын өрхийн бүртгэлийн дэвтэр, иргэний үнэмлэх 5) санхүүгийн орлого, зарлагын мэдээлэл, хөрөнгийн эх үүсвэрийн тодорхойлолт, 6) байгууллагын үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж буй байршлын тодорхойлолт, санал болгож буй талбайн техник эдийн засгийн үндэслэл, архитектурын хэв маягийн дүрслэл зэрэг болно.

Шашны байгууллага байгуулах шаардлага, үйл ажиллагааны онцлогийг тусгасан өргөдөл, шашны байгууллагын бүтэц, үйл ажиллагааны хамрах хүрээ, хэлбэр, шашны байгууллагын үндсэн мэдээлэл (сүм хийдийн нэр, хаяг, шашны харьяалал, анхдагч хөрөнгөийн хэмжээ), шашны байгууллага байгуулахаар санаачлагчид ба лам санваартны үндсэн мэдээлэл (овог нэр,

хүйс, боловсрол, мэргэжил, эрхэлж бий ажил, гэрийн хаяг, утас) зэрэг нь бүрдүүлэх чухалтай бичиг баримт юм.

Хятадад шүтэж итгэдэг номлолын үндсэн үзэл санаа, үйл ажиллагааны зарчим, гадаад харилцааг тайлбарласан танилцуулга, сүм хийдээс шүтэн бишрэгчид, итгэгчдийн дундах зохиох ажлын гол агуулга, чиглэл зэрэг бичиг баримтыг энэ үе шатанд шаарддаггүй нь аргад сүм хийдийн хууль эрх зүй, үндэс, нийгэм, соёлын үүрэг, хариуцлагыг тогтоосонтой холбоотой гэж үзэж байна. Тус аргын 8 дугаар зүйлийн нэгдүгээр тогтоолд шашны байгууллага байгуулах үндсэн зорилт, зарчим нь улсын “Шашны хэргийн журам”-ын 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйлийг зөрчиж болохгүй гэж тогтоожээ.

“Шашны хэргийн журам”-ын 4 дүгээр зүйлд зааснаар “Төр нь шашны хэвийн үйл ажиллагааг хуулийн дагуу хамгаалж, шашныг социалист нийгэмд зохицоход идэвхтэй чиглүүлж, шашны бүлгэм, шашны сургууль, сүм хийд, сүсэгтний хууль ёсны эрх, ашгийг хамгаална. Харин Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар төрийн байгууллага шашны, сүм хийд улс төрийн үйл ажиллагаа эрхлэн явуулж болохгүй бөгөөд шашны байгууллага, сүсэгтний хууль ёсны эрх ашгийг хамгаалах тухай ямар нэгэн агуулга Монголын хууль, тогтоомжид байхгүй болно.

“Шашны хэргийн журам”-ын 4 дүгээр зүйлд зааснаар “шашны бүлгэм, шашны сургууль, сүм хийд, сүсэгтэнд үндсэн хууль, хууль тогтоомж, дүрэм, журмыг сахин мөрдөж, социалист үзэл баримтлалын үндсэн үнэт зүйлсийг (хүчирхэг, ардчилалтай, боловсон, эв найрамдуу, эрх чөлөөтэй, эрх тэгш, голч, хуульжсан, эх оронч, ажилч хөдөлмөрч, үнэнч шударга, нөхөрсөг 富强、民主、文明、和谐, 自由、平等、公正、法治, 爱国、敬业、诚信和友善) чанарыг эрхэмлэн, үндэсний эв нэгдэл, угсаатны эв нэгдэл, шашны эв нэгдэл, нийгмийн тогтвортой байдлыг сахин хамгаалах ёстой.”

Аливаа байгууллага, хувь хүн шашныг ашиглан үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн, нийгмийн хэв журмыг алдагдуулсан, иргэдийн эрүүл мэндийг хохироосон, үндэсний боловсролын тогтолцоонд саад учруулсан, үндэсний эрх ашиг, нийгмийн нийтийн эрх ашиг, иргэдийн хууль ёсны эрх, ашиг хохироосон хууль бус үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Ямар ч байгууллага, хувь хүн өөр өөр шашны хооронд, сүсэгтэн болон шүтлэггүй иргэдийн хооронд зөрчил, мөргөлдөөн үүсгэж болохгүй, шашны хэт даврагч үзлийг сурталчлах, дэмжих, санхүүжүүлэхгүй байх, шашныг ашиглаж үндэсний эв нэгдлийг алдагдуулж, улс орноо хагалан бутаргах, террорист (恐怖) үйл ажиллагаа явуулж болохгүй”.

“Шашны хэргийн журам”-ын 5 дугаар зүйлд “Шашин бүр бие даасан байдал, өөрийгөө удирдах зарчмыг баримтлан, шашны бүлгэм, шашны сургууль, сүм хийдийн шашны үйл ажиллагаа нь гадны хүчний хяналтыг хүлээн зөвшөөрөхгүй. Шашны бүлгэм, шашны сургууль, сүм хийд, шашны зүтгэлтнүүд харилцан хүндэтгэх, эрх тэгш, найрамдлын үндсэн дээр гадаадад харилцах ёстой. Бусад байгууллага, хувь хүмүүс гадаад эдийн засаг, соёлын солилцооны ажиллагаанд шашны нэмэлт нөхцөлийг хүлээн зөвшөөрч болохгүй” гэсэн нь шашны байгууллагын “шаардагдах ном, судар”, “шүтэж итгэдэг номлолын үндсэн үзэл санаа, үйл ажиллагааны зарчим, гадаад харилцаа”, “шүтэн бишрэгчид, итгэгчдийн ажлын гол агуулга, чиглэл” зэргийг хууль эрх зүйн үүднээс тогтоохын хамт тэдний улс, нийгэм, соёлын үүрэг, хариуцлага, гадаад харилцааны дунд баримтлах зарчим зэргийг ч тодорхой заажээ.

Шашны байгууллагын бүртгэлийн хугацааг Монголын журамд тодорхой тогтоосонгүй, харин Хятадад 5- 7 жилээр хязгаарлажээ. Жишээлбэл, аргын 13 дугаар зүйлд “Бэлтгэх, байгуулах хугацаа ерөнхийдөө 5 жилээс хэтрэхгүй ... байгуулах ажлыг зөвшөөрлийн хугацаанд дуусгаагүй бол бэлтгэл ажлыг хангах, байгуулах зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр зохих ёсоор сунгаж болох боловч хамгийн урт хугацаа нь 2 жилээс хэтрэхгүй” гэж тодорхой тогтоосон байна.

Шашны байгууллагад үйл ажиллагааны зөвшөөрөл олгох

“Нийслэлийн нутаг дэвсгэрт шинээр сүм хийд байгуулах, үйл ажиллагаа явуулахад зөвшөөрөл олгох журам”-д зааснаар сүм хийд байгуулахад зөвшөөрөл олгох үйл явц дараах шатаар явна. Үүнд:

- Шашны байгууллага байгуулах зөвшөөрөл хүссэн өргөдөл болон шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн иргэдийн хурлын ажлын албанд өгнө.
 - Ажлын алба иргэдэд холбогдох хууль тогтоомжийг танилцуулна.
 - Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын хэсэг бичиг баримтыг хянан, дүгнэлт гаргаж тэргүүлэгчдийн хуралдаанд оруулна.
 - Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн хуралдаан олонхийн саналаар шийдвэрлэнэ.
 - Зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгоно. /Ховд аймаг 6 сар, Баян-Өлгий аймаг 5 жил байна./
- Нийслэл болон Дундговь аймагт бурханы шашны сүм хийд, дацан, төв байгуулах бол Монголын Бурхны шашинтны төвөөс үйл ажиллагааны тодорхойлолт авах ёстой. Увс, Ховд, Төв аймгийн журамд тухайн нутгийн иргэдийн санал, багийн иргэдийн санал авах заалт оруулсан. Булган аймгийн журамд Монгол улсад байдаггүй “төр, сүм хийдийн асуудал хариуцсан төрийн төв байгууллага, газар”-ын албан ёсны санал дүгнэлт” авсан байх заалт оруулсан байна.

Монголд тус нутаг дэвсгэрт уг сүм хийд, цуглаан шаардлагатай эсэхийг “хянан шалгах” ажлыг зөвшөөрлийн явцад гүйцэтгэдэг. Төр сүм хийдийн харилцааны хуулийн 4 дүгээр бүлгийн 4.8 “лам, санваартан нарын үнэмлэхүй тоо, сүм хийдийн байршлыг төрөөс хянан зохицуулна” гэсэн заалт дагуу ажлын хэсгээс хянан үзэж, санал дүгнэлтээ оруулах ёстой. Иймд хэрэв ажлын хэсгээс “хянан шалгах” явцад лам нарын үнэмлэхүй тоо, сүм хийдийн байршлын байдал хэмжээнээс хэтэрсэн гэж үзвэл тухайн шашны байгууллагыг байгуулах, улмаар бүртгүүлэх ажил хүчингүй болох юм.

Хятадын аргын 12 дугаар зүйлд “Шийдвэр гаргахын өмнө тойрог (区)-ын шашны хэрэг эрхлэх хэлтэс ба муж (өөртөө засах орон) -ын шашны хэрэг эрхлэх хэлтэс газар дээр нь шалгалт хийж, шаардлагатай бол санал асуулгын хурал (Hearing, 听证会) хийх ёстой” гэж тогтоожээ.

Журамд шашны байгууллагын үйл ажиллагааны зөвшөөрөл олгох хугацааг тодорхой тогтоосонгүй. Хятадад ажлын 30 өдрөөр хязгаарлажээ. Тухайлбал, аргын 17 дугаар зүйлд муж (өөртөө засах орон)-ын шашны хэрэг эрхлэх хэлтсээс “бүртгүүлэх байгууллагын өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30 өдрийн дотор шашны үйл ажиллагаа явуулах газрын нэр, байгууллагын дүрэм, журам зэрэгтэй танилцаж, болзол хангасныг бүртгэн, шашны үйл ажиллагаа явуулдаг газрын бүртгэлийн гэрчилгээ” олгоно. Шашны байгууллага (сүм хийд) нь “Шашны байгууллагын(сүм хийд) бүртгэлийн гэрчилгээ” авсаны дараа шашны үйл ажиллагаа явуулах боломжтой” гэж тогтоосон нь бэлтгэл ажлаа дуусгасан шашны байгууллагын ажлыг хууль ёсны болгож, сүсэгтний шүтлэг бишрэлийн хэрэгцээг цаг тухайд нь хангахад ашигтай байдаг.

Журамд “Шашны үйл ажиллагаа явуулах газар байгуулах хүсэлтийг зөвшөөрсний дараа шашны үйл ажиллагаа явуулах газрын бэлтгэл ажлыг хийж болно”; “Шашны үйл ажиллагаа явуулах газрыг зөвшөөрөлтэйгээр бэлтгэх, барилгын ажил дууссаны дараа оршин суугаа Шиан, хошууны (县) түвшний ардын засгийн газрын шашны хэрэг эрхлэх хэлтэсд бүртгүүлэх хүсэлт гаргах ёстой. Шиан, хошууны (县) түвшний ардын засгийн газрын шашны хэрэг эрхлэх хэлтэсд нь өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шашны үйл ажиллагаа явуулах газрын удирдлагын зохион байгуулалт, дүрэм, журам зэргийг хянан үзэж, болзол хангасан бол бүртгэж, “Шашны үйл ажиллагаа явуулах газрын бүртгэлийн гэрчилгээ” олгоно”;

“Шашны үйл ажиллагаа явуулах газар нь хуулийн этгээдийн нөхцөлийг хангасан бол тухайн орон нутгийн шашны бүлгээс зөвшөөрөл авч, тухайн Шиан, хошууны (县) ардын засгийн газрын шашны хэрэг эрхлэх хэлтэсд шалгуулж, иргэний хэргийн хэлтэст очиж хуулийн этгээдээр бүртгүүлэх боломжтой” ; “Шашны үйл ажиллагаа явуулах газар бүртгэлээ дуусгавар болгох эсвэл бүртгэлийн агуулгыг өөрчилсөн тохиолдолд Бүртгэлийн менежментийн анхны агентлагд очиж Бүртгэлийг цуцлах (хүчингүй болгох) эсвэл өөрчлөх Бүртгэлийн гар гүйцэтгэл хийх хэрэгтэй” хэмээн зохицуулжээ.

Ийнхүү Монгол улс ба БНХАУ дахь шашны байгууллага бүртгүүлж, ажиллуулах зөвшөөрөл олгох хууль тогтоомжийг харьцуулж үзвэл эрх зүйн баримт бичгийн эрэмбэ, нэгдмэл байдал, процессын зарим үйл явц адил бус зүйл багагүй байна.

БНХАУ-ын Үндсэн хуульд заасанчлан төрөөс шашны хэвийн үйл ажиллагааг хамгаалах бөгөөд шашин шүтлэгийг ашиглан нийгмийн хэв журам алдагдуулах, иргэдийн эрүүл мэнд хохироох, үндэсний боловсролын тогтолцоонд саад учруулах үйл ажиллагаа явуулах, мөн гадаадын хяналтыг хориглосон байна.

Харин Монгол Улсын Үндсэн хуульд төр шашин хоёр харилцан хүндэтгэх ба тэдний үйл ажиллагааг заагласан, төр сүм хийдийн харилцааг хуонар зохицуулна гэж заасан боловч Төр сүм хийдийн харилцааны тухай хуульд тодорхой зохицуулсан заалтууд дутмаг байна.

Хоёр улсын шашны харилцааг зохицуулах хууль бүтэц, хэмжээний хувьд нэлээн зөрүүтэй, БНХАУ-ын "Шашны хэргийг зохицуулах хууль" илүү тодорхой зохицуулалтуудтай бөгөөд шашны байгууллага байгуулах, бүртгүүлэх, үйл ажиллагаа явуулах талаарх харилцааг улсын хэмжээнд нэг журмаар зохицуулсан нь даруй сайн туршлага мөн гэж үзэж байна.

Харин хоёр улсад шашны байгууллагууд холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгүүлж, зөвшөөрөл авч, үйл ажиллагаа явуулдаг нийгмийн институци нэг төрөл байна. Гэхдээ Монгол улсын тухайд аймаг бүр тусгай журамтай байгаа одоогийн практикийг халж, улсын хэмжээнд нэг журамтай болох нь зүйтэй гэж үзэж байна.

Монгол улсын эрх зүйн систем, улс төрийн тогтолцооны онцлог байдал, төрийн бодлогод нийцүүлэн БНХАУ-ын хууль, журмын зарим зохицуулалтын сайн туршлагыг судалгаа, үндэслэлтэйгээр хэрэгжүүлэх арга замыг эрэлхийлэх нь зүйтэй байна.

Шашны байгууллагуудын төртэй харилцах харилцааны хувьд системийн үзэл онолын шинжтэй ялгаа байгаа боловч, аль аль сүсэгтнүүдийн итгэлийн хэрэгцээг хангах чадавхитай байна.

Ном зүй

Монгол хэл дээр

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Төр сүм хийдийн харилцааны тухай Монгол улсын хууль
3. Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт төр, сүм хийдийн харилцааг зохицуулах журмын эмхэтгэл. (2023). Улаанбаатар.
4. Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө. Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл. (2024). Улаанбаатар. Иргэний үндсэн эрх хөгжил ТББ.

Хятад хэл дээр

1. БНХАУ-ын Иргэний хууль(中华人民共和国民法典), 法律出版社, 2024年.
2. Шашны хэргийн журам Шашны Үйл Ажиллагаа Явуулах Газрын (Шашны Байгууллага,Сүм Хийд) менежментийн Арга (宗教事务条例 宗教活动场所管理办法), 法律出版社, 2024年.

3. 美国, 詹姆斯·戈德雷·阿瑟·泰勒·冯·梅伦, 私法比较研究导论: 阅读、案例、材料, 张淞纶译, 中国法制出版社, 2021年, 第一版序言.
5. 刘浩然, 社会科学比较研究方法: 发展、类型与争论, 世界社会科学, 2018年第1期, 122~133页.
6. 沈宗灵, 比较法研究, 北京大学出版社, 2004年。

A Comparative Analyses of The Laws of Mongolia and People's Republic of China on Religious Organizations

In this article, we attempted to comparatively analyze the legal regulations governing the relationship between the state and religious institutions in Mongolia and the People's Republic of China (PRC). We focused on the policies of the two countries regarding the establishment, licensing, registration, and operation of religious organizations, identifying similarities and differences, and explaining good and instructive practices. For this purpose, we primarily used Mongolia's Law on the Relationship between the State and Religious Institutions, the procedures for granting permission to establish and operate new monasteries in the capital and provincial territories, and China's Measures for the Management of Religious Activity Sites (Religious Organizations, Monasteries) as our main sources.